



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 87/08

Номгон

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгох тухай

ГХГЗЗГазрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 10 дугаар зүйлийн 10.17 дахь заалт, Засгийн газрын 2003 оны 205 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Номгон 1 дүгээр багт байрлах Худалдааны үндэсний дээд сургуулийн 000437060 дугаартай Газар эзэмших эрхийн гэрчилгээг үрэгдүүлсэн тул тус гэрчилгээг хүчингүй болгосугай.
2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосонтой холбогдуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг нөхөн олгохыг Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн /С.Должинсүрэн/-д даалгасугай.
3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосоныг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлаж холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг Мэдээлэл технологийн асуудал хариуцсан ажилтан /Ч.Анхбаяр/-т даалгасугай.
4. Үрэгдүүлсэн газар эзэмших эрхийн гэрчилгээний үнийг 1,5 дахин нэмэгдүүлж төлөхийг Худалдааны үндэсний дээд сургуулийн захирал /Г.Батмөнх/-д даалгасугай.

ДАРГА

Д.АЛТАНГЭРЭЛ

2518019